

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/299/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/134

танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.РЭГЗЭДМАА ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант онд 32,227.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

019020255

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж

авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	133,268,029.09	182,694,856.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	49,798,837.98	70,897,806.49
312	Банканд байгаа бэлэн мөнгө	49,798,837.98	70,897,806.49
3121	Төгрөг	49,798,837.98	70,897,806.49
31	Төрийн сангийн харилцах	49,798,837.98	70,897,806.49
33	АВЛАГА	0.00	0.01
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	0.00	0.01
35	БАРАА МАТЕРИАЛ	83,469,191.11	111,797,050.11
354	Хангамжийн материал	81,939,191.11	8,547,050.11
35410	Бичиг хэргийн материал	1,328,650.00	2,887,250.00
35420	Аж ахуйн материал	77,472,240.49	103,691,631.49
35460	Хүнсний материал	2,057,638.02	887,506.02
35470	Бусад хангамжийн материал	1,080,662.60	1,080,662.60
35600	Мал, амьтад	1,530,000.00	3,250,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,917,721,868.00	1,849,912,626.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,917,721,868.00	1,849,912,626.76
392	Биет хөрөнгө	1,889,521,868.00	1,820,712,626.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,794,312,875.41	1,794,312,875.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	(112,380,930.12)	(142,286,144.64)
39205	Машин тоног төхөөрөмж	130,761,369.00	145,253,839.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,590,006.58)	(40,689,562.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,988,719.75	68,824,857.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,674,745.66)	(23,158,578.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,944,750.00	14,944,750.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,318,750.17)	(10,193,750.21)
39217	Номын фонд	18,478,586.37	13,704,340.46
393	Биет бус хөрөнгө	29,200,000.00	29,200,000.00
39301	Программ хангамж	670,000.00	670,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(670,000.00)	(670,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,200,000.00	29,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,050,989,897.09	2,032,607,483.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,557,582.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,557,582.00	0.00
413	Өглөг	2,557,582.00	0.00
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг	2,557,582.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,048,432,315.09	2,032,607,483.37
51	Засгийн газрын хувь оролцоо	2,048,432,315.09	2,032,607,483.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	393,366,267.38	393,366,267.38
51101	Өмч:-төрийн	393,366,267.38	393,366,267.38
512	Хуримтлагдсан үр дүн	253,289,816.87	237,464,985.15
51210	Өмнөх үеийн үр дүн	253,289,816.87	253,289,816.87
51220	Тайлант үеийн үр дүн		(15,824,831.72)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,401,776,230.84	1,401,776,230.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,050,989,897.09	2,032,607,483.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	878,994,006.00	86,4107,563.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	323,755,806.00	39,701,263.00
120	Нийтлэг татварын бус орлого	151,887,806.00	39,701,263.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	151,887,806.00	39,701,263.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,023,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,450,648.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	151,887,806.00	32,227,515.00
	Тусламжийн орлого	171,868,000.00	0.00
122005	Төсвөөс санхүүжих	171,868,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,453,200.00	824,406,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	540,785,000.00	653,445,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,453,200.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	14,453,200.00	0.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	170,961,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	170,961,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	714,742,077.23	867,455,814.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	714,742,077.23	867,455,814.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	697,350,484.21	861,301,579.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,739,078.27	484,269,529.00
210101	Үндсэн цалин	296,356,995.89	354,715,823.99
210102	Нэмэгдэл	78,408,784.09	107,996,636.89
210104	Урамшуулал	25,973,298.29	21,557,068.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,470,191.58	61,801,258.48
210201	Тэтгэврийн даатгал	34,758,395.54	39,202,764.24
210202	Тэтгэмжийн даатгал	3,988,422.69	5,342,375.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,126,898.00	3,859,360.20
210204	Ажилгүйдлийн даатгал	779,230.12	946,177.72
210205	Эрүүл мэндийн даатгал	7,817,245.23	12,450,581.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,433,234.00	164,341,414.78
210301	Гэрэл, цахилгаан	4,913,210.00	4,714,591.28
210302	Түлш, халаалт	142,320,024.00	159,626,823.50
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	7,168,374.00	7,399,435.00
210401	Бичиг хэрэг	2,315,000.00	1,342,150.00
210402	Тээвэр, шатахуун	1,605,124.00	2,100,440.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,248,250.00	2,327,600.00
210408	Бараа материал акталсны зардал		1,629,245.00
2105	Норматив зардал	38,049,689.98	52,632,442.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,100.00	103,650.00

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	37,929,589.98	52,528,792.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	15,200.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	15,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,829,800.00	3,616,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	756,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	2,829,800.00	2,860,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,668,116.38	87,226,300.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,053,900.00	4,835,000.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2,588,000.00	1,133,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,026,216.38	81,258,300.48
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,383,593.02	6,154,235.22
	Бусад урсгал шилжүүлэг	16,333,200.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,880,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,453,200.00	0.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	1,050,393.02	6,154,235.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,050,393.02	6,154,235.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	164,251,928.77	(3,348,251.96)
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		12,476,579.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(12,476,579.76)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	154,251,928.77	(15,824,831.72)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,366,267.38	1,401,916,310.84	88,897,808.10	1,884,180,386.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			140,080.00	140,080.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	393,366,267.38	1,401,916,310.84	89,037,888.10	1,884,320,466.32
Дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэн дүн				
Тайлант үеийн үр дүн			164,251,928.77	164,251,928.77
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,366,267.38	1,401,776,230.84	253,289,816.87	2,048,432,315.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	393,366,267.38	1,401,776,230.84	253,289,816.87	2,048,432,315.09
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			(15,824,831.72)	(15,824,831.72)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,366,267.38	1,401,776,230.84	237,464,985.15	2,032,607,483.37

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	727,106,200.00	831,880,048.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	171,868,000.00	7,473,748.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	7,473,748.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	7,473,748.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,023,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	6,450,648.00
	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	171,868,000.00	0.00
122005	Улсын төвлөрсөн төсвөөс	171,868,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	555,238,200.00	824,406,300.00
131001	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	540,785,000.00	653,445,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,453,200.00	0.00
131101	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчаас	14,453,200.00	0.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		170,961,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		170,961,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	677,307,362.02	790,349,379.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	677,307,362.02	790,349,379.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	644,347,729.00	762,711,014.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,176,219.42	491,804,106.84
210101	Үндсэн цалин	294,794,137.04	352,820,694.61
210102	Нэмэгдэл	78,408,784.09	111,134,733.70
210104	Урамшуулал	25,973,298.29	27,848,678.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,470,191.58	56,824,262.65
210201	Тэтгэврийн даатгал	34,758,395.54	38,844,579.83
210202	Тэтгэмжийн даатгал	3,988,422.69	4,568,811.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,126,898.00	3,620,112.33
210204	Ажилгүйдлийн даатгал	779,230.12	886,365.28
210205	Эрүүл мэндийн даатгал	7,817,245.23	8,904,393.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,131,908.00	163,806,864.78
210301	Гэрэл, цахилгаан	5,541,710.00	4,714,591.28
210302	Түлш, халаалт	140,871,968.00	158,372,273.50
210303	Цэвэр, бохир ус	718,230.00	720,000.00
2105	Норматив зардал	22,400,360.00	29,743,030.00
210502	Хоол, хүнс	22,400,360.00	29,743,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,732,100.00	3,616,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	777,400.00	756,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,954,700.00	2,860,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,436,950.00	15,916,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,078,100.00	11,627,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,358,850.00	4,289,150.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,959,633.02	27,638,365.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,309,240.00	21,484,130.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	17,456,040.00	21,484,130.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,453,200.00	
	Төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,050,393.02	6,154,235.22
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,050,393.02	6,154,235.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,798,837.98	41,530,668.51
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	20,431,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	20,431,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	20,431,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	20,431,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	(20,431,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	49,798,837.98	21,098,968.51
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	49,798,837.98
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,798,837.98	70,897,806.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		49,798,837.98	(49,798,837.98)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	877,234,100.00	8,046,268,644.27	72,67,255.73	91.7%
УРСГАЛ ЗАРДАЛ	877,234,100.00	804,626,844.27	72,607,255.73	91.7%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	849,093,400.00	783,142,714.27	65,950,685.73	92.2%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	533,382,300.00	491,804,106.84	41,578,193.16	92.2%
Үндсэн цалин	373,622,500.00	352,826,694.61	20,801,805.39	94.4%
Нэмэгдэл	139,354,300.00	111,134,733.70	28,219,566.10	79.7%
Урамшуулал	20,450,500.00	27,848,678.53	(7,443,178.53)	136.5%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	66,672,800.00	56,824,262.65	9,848,537.35	85.2%
Тэтгэврийн даатгал	45,337,500.00	38,844,579.83	6,492,920.17	85.7%
Тэтгэмжийн даатгал	5,333,800.00	4,568,811.90	764,988.10	85.7%
ҮОМШӨ-ний даатгал	4,267,100.00	3,620,112.33	646,987.67	88.1%
Ажилгүйдлийн даатгал	1,066,700.00	886,365.28	180,334.72	83.1%
Эрүүл мэндийн даатгал	10,667,700.00	8,904,393.31	1,763,306.69	83.5%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	169,961,100.00	163,806,864.78	6,154,235.22	96.4%
Гэрэл, цахилгаан	7,499,200.00	4,714,591.28	2,784,608.72	62.9%
Түлш, халаалт	161,741,900.00	158,372,273.50	3,369,626.50	97.9%
Цэвэр, бохир ус	720,000.00	720,000.00		100%
Норматив зардал	41,558,100.00	29,743,030.00	11,815,070.00	71.6%
Хоол, хүнс	41,558,100.00	29,743,030.00	11,815,070.00	71.6%
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00		100.0%
Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00		100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,883,100.00	3,616,000.00	267,100.00	93.1%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,023,100.00	756,000.00	267,100.00	73.9%
Мэдээллийн технологийн зардал	2,860,000.00	2,860,000.00		100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	32,636,000.00	36,348,450.00	(3,712,450.00)	111.4%
Бараа ажил үйлчилгээний бусад зардал	28,345,900.00	32,059,300.00	(3,713,400.00)	113.1%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,290,100.00	4,289,150.00	950.00	100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,140,700.00	21,484,130.00	6,656,570.00	76.3%

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусад урсгал шилжүүлэг	28,140,700.00	21,484,130.00	6,656,570.00	76.3%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	28,140,700.00	21,484,130.00	6,656,570.00	76.3%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	824,406,300.00	831,880,048.00	(7,473,748.00)	100.9%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	653,445,200.00	653,445,200.00		100.0%
Улсын төсвөөс санхүүжих	653,445,200.00	653,445,200.00		100.0%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	170,961,100.00	170,961,100.00		100.0%
Орон нутгийн төсвөөс	170,961,100.00	170,961,100.00		100.0%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		7,473,748.00	(7,473,748.00)	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,023,100.00	(1,023,100.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		6,450,648.00	(6,450,648.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		49,798,837.98	49,798,837.98	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		70,897,806.49	(70,897,806.49)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	29	29		100.0%
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	19	19		100.0%
Үйлчлэх ажилтан	9	9		100.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрхэм зорилгоо “Хүүхэд бүр тоглоомын орчинд өөртөө итгэлтэй, чөлөөтэй сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх, хүсэл сонирхолдоо хөтлөгдсөн, идэвхтэй суралцагч байхад нь үлгэрлэн дагуулж, хамтдаа хөгжих замаар хүүхэд бүрийг “Монгол хүн болгон төлөвшүүлнэ” гэжээ. Тус байгууллага анхан шатны боловсрол олгох үйл ажиллагааг эрхлэн явуулж байна

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, хэрэгжүүлэх 24 арга хэмжээтэй баталсныг 94%-тай хэрэгжүүлсэн гэж дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Ерөнхий боловсролын тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжуудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай (батлагдсан: 2022-11-04 хэрэгжиж эхлэх:2023-03-01)
- Монгол улсын үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай
- Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны санхүүгийн хяналт, шалгалтын ажил хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,382.4 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	49,798.8	70,897.8	21,099.0
Бараа материал	83,469.2	111,797.1	28,327.9
Үндсэн хөрөнгө	1,917,721.9	1,849,912.6	(67,809.3)
Нийт хөрөнгө	2,050,989.9	2,032,607.5	(18,382.4)
Өр	2,557.6		(2,557.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,048,432.3	2,032,607.5	(15,824.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,050,989.9	2,032,607.5	(18,382.4)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 70,897.8 мянган төгрөг болж, 21,099.0 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 28,327.9 мянган төгрөгөөр өссөн Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 13,350.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 6,963.0 мянган төгрөг, иргэдийн хандив 4,700.6 мянган төгрөг, нийт 25,013.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалаас шалтгаалж нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 2023 онд тоног төхөөрөмж 21,231.7 мянган төгрөг, тавилга эд хогшил 4,200.0 мянган төгрөг, номын фонд 493.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 20,431.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, Орон нутгийн хөгжлийн сангаас үнэ төлбөргүй хүлээн авсан 4,200.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 493.9 мянган төгрөг ном, нийт 5,493.9 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авснаар үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна. Тайлант онд 17,371.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаар хөрөнгө буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,032,607.5 мянган төгрөг болж 15,824.8 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 547,480.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 170,961.1 мянган төгрөг, нийт 718,441.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 105,964.7 мянган төгрөгөөр өсгөн, 824,406.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 105,964.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 653,445.2 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 170,961.1 мянган төгрөг, нийт 718,441.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 653,445.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 170,961.1 мянган төгрөг, нийт 824,406.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож 6,154.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 653,445.2 мянган төгрөг буюу 91.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	71802- Ерөнхий боловсрол				
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,144.0	1,120.1	23.9	97.9
1.2	81806-Дотуур байр	66,888.3	52,279.1	14,609.2	78.1
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	16,050.6	16,049.0	1.6	100.0
1.4	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,621.7	2,574.9	46.8	98.2
1.5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	463,440.9	428,150.0	35,290.9	92.4
1.6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	119,884.6	111,823.2	8,061.4	92.3
1.7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	1,144.0	1,120.0	24.0	97.9
1.8	80312 сургалт семинар	971.5	500.5	471.0	51.5
1.9	81801 үдийн цай хөтөлбөр	28,140.7	21,484.1	6,656.6	76.3
1.10	81827 бичиг үсгийн боловсрол	805.1	330.2	474.9	41.0
1.11	81844 гүнзгийрүүлсэн сургалт	6,300.7	6,269.1	31.6	99.5
1.12	81848 түрээсийн ном	1,023.1	756.0	267.1	73.9
	Дүн	708,415.2	642,456.2	65,959.0	91.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн нь Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 69,698.8 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Дотуур байрны хүүхдийн хоол хүнс 41,558.1 мянган төгрөг, үдийн хоол хүнс 28,140.7 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар тус бүр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 51,227.8 мянган төгрөгийн худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулахаар зарласан боловч оролцогч байхгүйн улмаас шууд гэрээ байгуулан ажилласан байна. Худалдан авалтын 18,471.0 мянган төгрөгөөр буурсан нь цэцэрлэгийн хүүхдийн тоо багассантай холбоотой болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн боловч санхүүгийн тайланг залруулан эцсийн байдлаар баталгаажуулан 2024 оны 02 дугаар сарын 26 өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь батлагдсан 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 714,742.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,721.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,040.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын орон тоог хэмнэх, хавсран ажиллах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээс батлагдсан зардлаас байр ашиглалттай холбоотой зардлыг 6,154.2 мянган төгрөг, норматив зардлыг 11,815.1 мянган төгрөг, нийт 17,969.4 мянган төгрөгөөр төсөвт зардлыг хэмнэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 171 мэдээллээс 154 мэдээллийн хугацаандаа, 15 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа хоцроон мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж ,1 албан шаардлага, өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 16 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,025.5	1	2,025.5	100%
Зөвлөмж	3	148,328.8	3	148,328.8	100%
Нийт дүн	4	150,354.3	4	150,354.3	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 59,609.4 мянган төгрөгийн алдаа¹илэрснээс аудитын явцад 59,609.4 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийн дүн 49,873.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь, УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын дүнгээс 9,736.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг" гэсэн стандарт, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 10,387.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 967.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 9,420.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

НДШ тайлантай цалингийн хүснэгтийг тулган шалгахад ажиллагсдын цалингаас НДШ-ийг тооцоходоо 967.2 мянган төгрөгөөр дутуу тооцож суутган тайлагнасан нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12-т "Энэ хуулийн 7.4.3-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын зохих санд ажил олгогч сар бүр төлнө" гэж заасантай нийцэхгүй, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн суутган тооцоогүй татварыг холбогдох этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” г гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” э хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх Бараа материалд 9,420.0 төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг ангилал зөрүүлэн бүртгэж тайлагнасан байгаа нь УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга-Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал "Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт 6. Бараа материал "Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна" Санхүүгийн тайланд бараа материалыг дараах байдлаар тодруулна. Үүнд: (а) Түүхий эд материал, үндсэн түүхий эд, туслах материал (б) Дуусаагүй үйлдвэрлэл, үйлдвэрлэж дуусаагүй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг, (в) Бараа, бэлэн бүтээгдэхүүн: борлуулах зориулалттай үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулах зорилгоор бусдаас худалдан авсан бараа;(г) Хангамжийн материал: аж ахуйн үйл ажиллагаанд ашиглагдах, цаашдаа зардал болгох хангамжийн материал, шууд зарцуулагдах багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, шатах тослох материал, бусад хангамжийн шинжтэй зүйлс хамаарна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалд бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг зохих данс бүртгэлд тусгах зөвлөмж хүргүүлэх

2. Хандив тусламжийн орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд эцэг, эхчүүд болон иргэд,төгсөгчдөөс авсан хандив тусламжаар үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа "Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан"-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь УСНББОУС-9 стандартын 17-д “Тухайн орлогыг хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмжих ба шилжүүлсэн аливаа мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулна. Хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй тохиолдолд орлогыг тухайн өгсөн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр орлогыг хэмжих ба шилжүүлсэн аливаа мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулна.”, Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1 Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль

/цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг "Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан"-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах харилцааг энэхүү дүрмээр зохицуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Буцалтгүй тусламжийн орлогыг холбогдох дүрэм журамд заасны дагуу бүртгэж тайлагнаж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдлийн дүн 49,873.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	49,873.2			1	49,873.2	1	49,873.2				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлын дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын дүнгээс 9,736.2 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	9,736.2			1	9,736.2	1	9,736.2				
Дүн	2	59,609.7			2	59,609.7	2	59,609.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг бараа материалд бүртгэсэн	1	9,420.0					1	9,420.0				
НДШ-ийг дутуу тооцсон	1	967.2	1	967.2								
Санхүүгийн тайланг цагалбарт хуулийн хугацаанд бэлтгээгүй	1	-							1	-		
Хандив тусламжийн орлогыг бүртгэхдээ сан байгуулж ажиллаагүй	1	-					1	-				
Дүн	4	10,397.2	1	967.2			2	9,420.0	1	-		



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 68-17225502-ТӨА-2024/299/НА-СТА-ТШЗ

Зуунмод сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ажилтан, албан хаагчдын цалингаас даатгуулагчийн НДШ-ийг 967,201.85 төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12-т "Энэ хуулийн 7.4.3-т заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос даатгуулагчийн болон ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, нийгмийн даатгалын зохих санд ажил олгогч сар бүр төлнө" гэж заасныг, Санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Т.Хишигсүрэнгээр 967,201.85 /есөн зуун жаран долоон мянга хоёр зуун нэгэн төгрөг наян таван мөнгө/ төгрөгийг төлүүлэн Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс дэх 100140090000 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Рэгзэдмаа, нягтлан бодогч Т.Хишигсүрэн нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019050351



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 123-17225502-ТӨА-2024/299/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан нягтлан бодогч Т.Хишигсүрэнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Рэгзэдмаа, нягтлан бодогч Т.Хишигсүрэн нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ